

## Телеологи идеализм буюу үнэлэмжийн талаарх

### Г.Лотцегийн үзэл баримтлал

**Б.Мөнхжавхлан**, доктор (PhD)

МУИС, Философи шашин судлалын тэнхим

**Б.Дагзмаа** доктор (PhD), профессор

МУИС, Философи шашин судлалын тэнхим

**Хураангуй:** Энэ өгүүлэлд Лотцегийн үнэлэмжийн онол дахь хүний мэдрэмж, гоо зүйн чадамжаар дамжин үнэлэмжийг ухамсарлах чадварыг хэрхэн тэрээр онцолсон болон үнэлэмжийн объектив шинжийг хэрхэн тодорхойлсныг авч үзэв. Г.Лотце үнэлэмжийг объектив, давтагдашгүй өвөрмөц шинжтэй, зорилготой зарчим мөн гэж үзсэнээрээ телеологи, идеалист үзэл баримтлалыг боловсруулсан. Түүний философийн гол зорилго нь хууль, баримт, үнэлэмжийн шалгуур гурвыг нэгэн цогц ойлголтоор уялдуулах явдал байв. Тэрээр үнэлэмжийн шалгуурыг таашаал, өвдөлтийн мэдрэмжээр илэрхийлсэн бөгөөд энэ бол бодитой оршдог зүйл гэж тайлбарласан байна. Түүний үзсэнээр, үнэлэмжийн уг сурвалж бол Абсолют буюу Хамгийн Дээд Сайн бөгөөд бүх бодит байдал түүн рүү чиглэдэг. Лотце, үнэлэмжийг амьд, идэвхтэй гэж ойлгож, хүнийг зөвхөн үнэлэмжийн мэдрэгч биш бас бүтээгч, хэлбэржүүлэгч гэж тодорхойлсон байдаг нь түүний боловсруулсан үнэлэмжийн тухай үзэл баримтлал хүний асуудалд төвлөрсөн телеологи философи гэдгийг харуулахыг оролдсон аж.

**Түлхүүр үг:** үнэлэмж, телеологи, зорилго, гоо зүй, бурхан тэнгэр, бүхэллэг оюун

Гегелиэс хойшхи германы философи дахь метафизикийн талбарт Г.Лотце чухал байр суурь эзлэх болсон нь түүний боловсруулсан үнэлэмжийн тухай үзэл баримтлалтай холбоотой. Лотцегийн философи Г.Лейбниц, И.Кант, В.Гегелийн сэтгэлгээ, мөн реализм ба романтизмын элементүүдийг нэгтгэхийг оролдсон эклектик шинжтэй. “Лотцегийн сургууль” гэдэг бие даасан философи чиглэл бий болоогүй ч түүний үзэл баримтлалаас урам авсан олон сэтгэгчид бий (Pierson, 1988). Түүний үзэл баримтлал Ж.Сантаяна, Ж. Ройс, У. Жеймс, Ж. Дьюи, А.Н. Уайтхед, В. Виндельбанд, Х.Риккерт нарын философид ихээхэн нөлөө үзүүлсэн аж. “Үнэлэмж” бол Лотцегийн философийн үндэс суурь төдийгүй түүний орчин үеийн сэтгэлгээний хамгийн өвөрмөц, урт хугацаанд үлдэх хувь нэмэр гэж Ф.Ж. фон Ринтелен тодорхойлсон (Pierson, 1988) байдаг. Лотце 1856-1864 онд “Бичил орчлон” гэсэн гурван боть бүтээл хэвлүүлэхийн сацуу “Философийн систем буюу Логик” (1874), “Метафизик” (1879) зэрэг ном бичсэн бөгөөд гоо зүй, ёс зүй, шашны талаар бичсэн түүний эцсийн боть хэвлэгдэж амжаагүй юм.

Энэхүү өгүүлэлд Лотце үнэлэмжийг бодит байдлын онтологи үндэс болохыг хэрхэн тодорхойлсныг задлан шинжлэх мөн түүний боловсруулсан телеологи идеализм дахь механицизм ба Абсолют Сайны тухай ойлголтын метафизик утга холбогдлыг тодруулахыг зорив. Тэрээр ертөнцийг телеомеханизмын зарчмаар тайлбарлахыг эрмэлзэхдээ “бүхэллэг оюун”, “зургаа дахь мэдрэхүй” хэмээх ойлголтуудаар дамжуулан онолоо боловсруулсан билээ.

Лотце нь бодит байдал, танин мэдэхүй, соёлын аливаа талбарт хэрэгжиж буй мэдлэгийг шинжлэхийг эрмэлзэж байв. Мөн шинжлэх ухааны угтал нөхцөл болж буй суурь ойлголтуудыг судалж, тэдгээрийн хэрэглээний хязгаарыг тогтоохыг зорьсон юм. Түүний философи баримтлалыг гурван хэсэг болгон авч үзвэл, нэгдүгээрт нь метафизикийн асуудал буюу ахуйн түгээмэл хуулиуд ба зарчмуудыг, хоёрдугаарт тус

хууль, зарчмын хэрэглээ буюу космологи ба сэтгэл судлалыг, гуравдугаарт нь гоо зүй, ёс зүйн үнэлэмжийн шалгуурыг тэрээр тус тус судлан үзэхийг зорьсон байна.

Түүний философийн гол зорилго нь хууль, баримт, үнэлэмжийн шалгуурыг судлах явдал бөгөөд тэдгээрийг нэгэн бүхэллэг *оюунд* нийцүүлэн багтаах ерөнхий ойлголтыг бүрдүүлэхэд оршиж байсан юм. Лотцегийнхоор гагцхүү бүхэллэг оюунд баримтын ертөнц, ёс суртахууны болон гоо зүйн хэмжүүрүүд ахуйн түгээмэл хуулиар дамжин биелэлээ олж байдаг. Ийм нэгдлийг, тэрээр Бурхан тэнгэрийн санаа хэмээн үзсэн. Учир нь Бурхан тэнгэр ертөнцийг бүтээж, хадгалан үлдээхдээ тодорхой хэлбэр ба хуулийг бий болгож тэдгээр нь байгалийн үзэгдлүүдээр дамжин өөрийн зорилгоо биелүүлдэг байна. Түүнийхээр ертөнц бол баримт, хууль, үнэлэмжийн хэм хэмжээний нэгдлээс бүтдэг ажээ (Milkov, 2006).

Лотце, үнэлэмжийг<sup>5</sup> универсаль, объектив, чиглүүлэгч зарчим гэж үзэв. Үнэлэмж тухайн зүйлд (объектод) язгуур байдлаар оршдог бөгөөд субъектэд буюу бидэнд таашаал, өвдөлт зэрэг мэдрэмжээр (Textor, 2025) дамжин үйл явдал, юмсын талаарх бидний туршлагад илэрдэг. Өөрөөр хэлбэл, үнэлэмж бол бидний хүсэл эрмэлзлэлээс огт хамаардаггүй боловч бидний мэдрэмж рүү хандаж байдаг (Ц.Гомбосүрэн, 1990-ээд оноос хойших Монголын философийн амьдрал, 2019). Мэдрэмж харин янз бүрийн үнэлэмжийг бий болгож, тогтоон барьж байдаг. Үнэлэмж ийнхүү мэдрэмжээр дамжин оюун ухаанд илэрч байдаг бөгөөд Лотце ингэж үзсэнээ телеологийн идеализм хэмээн нэрлэсэн юм. Түүнийхээр бүх зүйл өөрийн дотоод механизм буюу зорилгот шинжтэй бөгөөд байгальд телеомеханизмын зарчим ноёрхож байдаг аж. Лотцегийн *телеомеханизм* утгаа шинжлэх ухаан, телеологи хоёрын нэгтгэх гэсэн философийн оролдлого юм. Өөрөөр хэлбэл: юмс хэрхэн өрнөдгийг тайлбарлах механик үзлийг тэрээр хүлээн зөвшөөрөхийн сацуу тэдгээр нь яагаад чухал, ямар утгатайг тайлбарлах телеологийн ойлголтын ач холбогдлыг нэгтгэсэн үзэл баримтлал боловсруулжээ.

Шинжлэх ухааны байгалийн хуулиуд, хүчний тухай бидний ойлголт, төсөөлөл байгалийн юмс бодитоор хэрхэн үйлчилж, ажилладаг болохыг бүрэн тайлбарлаж чаддаггүй. Үүнийг ойлгохын тулд бид тэдгээрийг мэдрэхүйн хүрээнээс чинагш оршихуй (*Übersinnliche*)-той холбох ёстой. Энэхүү “дээд мөн чанартай оршихуй” бидэнд эдгээр механик үйл явцыг жинхэнэ утгаар нь ойлгох боломжийг олгодог (Milkov, 2006) тухай үзэл баримтлалыг “телеомеханизм” гэж тэрээр нэрлэсэн юм. Гэхдээ түүний энэ үзлийг шүүмжилсэн зарим нэг үндэслэгчээр авч үзвэл эцсийн дүндээ механицизмд ямар асуудал байна вэ?

Механицизм нь амьд организмын оршихуй, үржихүйг тайлбарлахаас гадна нарийн төвөгтэй организм хэрхэн бий болдгийг ч тайлбарлаж чадна. Иймд телеологи үүднээс авч үзэх шаардлагагүй (Beiser, 2013) гэсэн тайлбар бий. Харин Мишел Вагнетти (Vagnetti, 2023), Лотцегийн үзлийн талаар бичихдээ байгалийн ертөнц нь инерцийн хуулийг дагадаг механик бүтэцтэй, харин оюун санааны ертөнц телеологийн зарчмаар зохион байгуулагдсан байдаг гэж түүний үзлийг дэмжин сайшаасан байна.

Лотцегийнхээр, байгальд өөрийн гэсэн идеал утга оршдог бөгөөд дан механицист тайлбар түүнийг нээж үл чадна<sup>6</sup>. Энэ идеал утга нь хүн төрөлхтний залуу үед бидний одоо домог зүй гэж нэрлэдэг мэдлэгт илэрч байсан бөгөөд, тухайн үед хүмүүс байгалийг амьд гэж боддог байв. Эртний философид энэ нь эцсийн шалтгааны талаарх онол, бүтээгдсэн юмсын хэрэгцээ, зорилгот шинжтэйн тухай санаануудад

<sup>5</sup> Wert

<sup>6</sup> Тэрээр анагаахын салбарын мэргэжилтэн байсан нь байгалийг судлах, шинжлэх ухаанд итгэл үнэмшилтэй байх, мөн шашныг судалж байсан тул мэдлэгийн эдгээр ялгаатай талбарт аль алинд нь нээлттэй ханддаг байсантай нь холбоотой.

илэрсэн байдаг. Өнөө үед энэ нь яруу найраг, урлагт оршиж байна (Т.М.Lindsay, 1876). Тэгэхээр тэрээр ертөнцийн талаарх шинжлэх ухааны тайлбарын зэрэгцээ идеалист байр суурийг баримталж түүнээ гоо зүйд холбон тайлбарлаж байсан аж.

Лотцегийнхоор “үнэлэмж” бол универсаль, бүх бодит байдалд оршдог, жинхэнэ, өвөрмөц бөгөөд мэдрэхүйн туршлага дахь бодит байдлын бие даасан хэсгүүд бүгдэд оршин чиглүүлж байдаг объектив зарчим буюу амьд сүнс<sup>7</sup> ажээ (Pierson, 1988). Ийнхүү тэрээр үнэлэмжийг дараах элементтэй гэж үзэв.

1. Объектив
2. Давтагдашгүй онцгой
3. Зорилготой

**1. Объектив шинж:** Үнэлэмжийг тодотгох шинжүүдийн эхнийх нь түүний объектив байдал юм. Объектив байдал бол тухайн танин мэдэгдэгч зүйлийн статус болон тухайн юмны талаар мэдлэг боловсруулж буй субъектийн хүлээн авах үйл ажиллагааг хамтад нь илэрхийлдэг. Лотце, бүх юм эсвэл үйл явдал нь танин мэдэгч субъектээсээ тусдаа бодитоор оршин буй байдлаар ойлгогдож мэдэгдэх боломжтой бөгөөд үнэлэмж бас субъектэд өөрийгөө объектив байдлаар илэрхийлж байдаг гэв. Энд Лотце хүний перцепц гадаад ертөнцийг тусгаж байгааг бус, харин ертөнцийн юмс, үзэгдэл өөрийн илрэх байдлаараа бидний мэдрэмж рүү хандаж буйг онцолжээ. Ингэснээр хүнд янз бүрийн үнэлэмжийг бий болгож, улмаар хүний хэрэгцээг тодорхойлон хөтөлдөг гэсэн байна. Ингэхдээ, “бид юмсын дотоод үнэлэмжээр хязгаарлагдаж байдаг...” (Lotze, p.695) гэжээ. Өөрөөр хэлбэл, үнэлэмж юмст уг язгуураараа оршдог учраас биднийг зайлшгүй хязгаарлаж захирдаг. Үнэлэмжийн туршлага бол дан “субъектив хариу үйлдэл” бус харин объектив феномен юм. Үнэлэмжийн тухай санаа нь зөвхөн мэдрэх чадвартай субъектийн хувьд л утга учиртай. Иймээс мэдрэмж бүх үнэлэмжийн суурийг бүрдүүлдэг гэдгээрээ онцгой ач холбогдолтой юм (Vida.F.Moore, p.21).

Үнэлэмж хүний оюун ухаанд мэдрэмжээр<sup>8</sup> дамжин мэдэгддэг. Мэдрэмж бол дуу, амт, хүрэлцэхүй, хараа, үнэр гэсэн туршлагын бусад мэдрэхүйтэй адил мадаггүй шинжтэй гэж нотлоход хүндрэлтэй ч үнэлэмж хэрэгжих чухал нөхцөл юм. Лотце хүний сэтгэл хөдлөлийн ач холбогдлыг тайлбарлахдаа: хүн төрөлхтний хувьд ямар нэгэн зүйлсийн үнэлэмжийг мэдрэх нь орлуулшгүй чухал гэж үзсэн. Объектив үнэлэмж туршлагад өгөгдөж буй юмс, үйл явдлаас авах таашаал, өвдөлтийн хэлбэрээр илэрнэ. Жишээ нь өвдөлт, таашаал бол зүгээр нэг “дотоод сэтгэлд тохиолдож буй үзэгдэл” биш, харин тухайн зүйл юм уу үйл явдлын дотор орших үнэлэмжийг бидэнд дамжуулж буй шууд илэрхийлэл юм гэжээ. Түүний ингэж үзсэн нь хүний танин мэдэхүй, түүнээс үүдсэн мэдрэмжүүд, зүгээр нэг субъектив хариу үйлдэл биш, харин юмс үзэгдэл, үйл явдлын доторх үнэлэмжийн объектив илэрхийлэл гэдгийн үндэслэгээ юм.

Тэрээр ‘зургаа дахь мэдрэхүй’-н (Pierson, 1988) тухай ойлголтыг бас дурдсан байдаг. Түүнийхээр, хүн мэдрэмжээрээ ямарваа юмны давуу эсвэл дутагдалтай талыг хүлээн зөвшөөрч байгаа нь, тухайн зүйл, үйл явдлын тухай үнэлэмжийн бодит илэрхийлэл юм. Лотце энэ үйл явц хэрхэн хэрэгждэгийг тайлбарлахдаа, үнэлэмжийг мэдрэх чадварыг “зургаа дахь мэдрэхүй” гэж үзэхээс илүү гоо зүйн чадварын хөгжилтэй холбосон байна. Мөн үнэлэмжийн мэдрэмж ач холбогдолтой гэдгийг хүмүүс үгүйсгэдэггүй тул Лотце ийм гоо зүйн чадвар үнэхээр оршин байдаг гэдэгт итгэж байсан. Иймээс “үнэлэмжийн өдөөгч”-тэй тулгарах үед, Лотцегийн хэлснээр, гоо зүйн чадамж эдгээр өдөөгчийг үнэлэмжийн ойлголт буюу мэдрэмж болгон

<sup>7</sup> Animate Geist

<sup>8</sup> feelings

хувиргадаг. Энэ нь тодорхой өнгөний өдөөгч (стимуляци) ‘улаан’ болж хувирдагтай төстэй үйл явц юм (Pierson, 1988).

Дээрх хоёр илэрхийллийг анзаарвал, нэгдүгээрт үнэлэмжийг бид бодитоор мэдэрч чаддаг, энэ нь хүний сэтгэлийн бүтэцтэй холбоотой. Үнэлэмж, тэрхүү тодорхой бүтцийн ачаар объектив байдлаар танигддаг бөгөөд энэ нь эцсийн дүндээ үнэлэмжийн объектив байдлыг тайлбарлахад субъектив элементийг оруулж ирдэг. Хоёрдугаарт, үнэлэмжийн мэдрэмжийг “бие махбодын мэдрэхүйн эрхтний мэдрэмжид суурилсан объектив сэтгэгдлүүдээр хүлээн авдаг” гэсэн.

Эдгээр үнэлэмжийн сэтгэгдлийг ойлголт болгон хувиргадаг бүтэц нь олон янзын нэртэй. Тэрээр “сэтгэл”, “үнэлэмжийг мэдэрдэг оюун ухаан” гэж нэрлэж байсан бөгөөд улмаар “бүхэллэг оюун”<sup>9</sup> гэж нэрээр нэрлэх болжээ. Тэгэхээр “*зургаа дахь мэдрэхүй бол бүхэллэг оюун*” юм. Лотцегийн хэлснээр: “Юмсын мөн чанар оюун бодолтой яг таг таардаггүй, оюун бодол үүнийг бүрэн барьж чадахгүй. Харин бүхэллэг оюун өөрийн үйл ажиллагаа, мэдрэмжээр дамжуулан бүх оршихуй, үйл явдлын мөн чанарыг мэдэрч чаддаг.” Эндээс харвал түүнийхээр үнэлэмж бол объектив гоо зүйн чадвараар ухамсарлагддаг, өвдөлт таашаалаар дамжиж мэдрэгддэг тийм өвөрмөц зүйл ажээ. Улмаар тэрээр, юмсын мөн чанар нь бодол санаанд оршдоггүй бөгөөд оюун бодол түүнийг бүрэн танин мэдэж чадахгүй. Харин бүхэллэг оюун өөрийн үйл ажиллагаа, мэдрэмжээр дамжуулан бүх оршихуй, үйл явдлын мөн чанарыг мэдэрч чаддаг. Үүний үр дүнд бүхэллэг оюун ийнхүү туршлагаар олж авсан зүйлийг түүний уг чанар шаардсан харилцаа холбоонд нь нэгтгэн оруулдаг бөгөөд энэхүү холбоог хэдий чинээ захирч чадна, төдий чинээ уг утга илүү гүн, илүү хүчтэйгээр мэдрэгдэнэ хэмээн үзжээ.

Бүхэллэг оюун хэмээх ойлголтоор дамжуулан Лотце хүний бүх төрлийн танин мэдэхүйн чадварууд нь харилцан хамааралтайг харуулахын сацуу үнэлэмжийг мэдрэх энэхүү чадвар нь цогц мэдлэгийг төлөвшүүлэхэд зайлшгүй шаардлагатай байдаг гэдгийг ийнхүү онцолсон аж. Аливаа үнэлэмжийг объектив байдлаар ухамсарлаж чаддагаараа “бүхэллэг оюун” нь бусад чадвараас онцгой ялгаатай, бие даасан шинжтэй бөгөөд хүний үнэлэмжийн объектив суурийг нь тодорхойлдог билээ. Лотцегийн боловсруулсан бүхэллэг оюун болоод танин мэдэхүйн чадварын харилцан хамаарлын тухай ойлголт түүний философийн метафизик агуулгыг илэрхийлдэг.

## 2. Давтагдашгүй онцгой<sup>10</sup> шинж

Лотце үнэлэмжийн объектив шинжийг тайлбарлахдаа үүнд зайлшгүй субъектив элементийн хувь нэмэр бий гэдгийг онцолдог. Энэ нь үнэлэмжийн давтагдашгүй чанар буюу онцгой шинж юм. Энэ элементийн ач холбогдол үнэлэмжийн объектив байдлаас илүү өргөн утгатай.

Давтагдашгүй онцгой чанар бол:

1. Аливаа зүйл эсвэл үйл явдал бүр өөрийнхөөрөө онцгой чанартай бөгөөд түүнд холбогдох үнэлэмж ч давтагдашгүй байдаг.
2. Үнэлэмж илрэх тэр мөчид хүлээн авч буй субъектийн нөхцөл байдал ч давтагдашгүй онцгой шинжтэй байдаг.

Өөрөөр хэлбэл Лотцегийн үзлээр онцгой цор ганц шинж бол танин мэдэгдэж болох юм бүр, үйл явдлын давтагдашгүй байдалтай холбоогдоод зогсохгүй мөн тэдгээрийг илэрхийлж байгаа үнэлэмжүүд, үнэлэмжийн өдөөгчид автсан танин мэдэгчийн онцгой, өвөрмөц нөхцөлд ч бас хамаатай байдаг. Тиймээс үнэлэмжийг мэдрэх үйл бүр нь дахин давтагдашгүй, онцгой өвөрмөц туршлага мөн бөгөөд нэг талаас үнэлэмжийн

<sup>9</sup> The whole mind

<sup>10</sup> Uniqueness

мөн чанарын тухай, нөгөө талаас танин мэдэгч субъект тэдгээр үнэлэмжтэй хэрхэн харилцдаг тухай юм.

**3.Зорилгот шинж:** Лотце, оршин буй бүх үнэлэмж өөрийн зорилготой гэж байв. Ингэж үзэж буй нь түүний философиог бүхэлдээ телеологи шинжтэй гэж үзэх үндэслэл болдог юм.

Бодит байдлыг шинжлэх нь бидэнд мадаггүй үнэний талаарх ухамсрыг, шууд өгөгдөж буй баримтыг ойлгуулдаг интуицийг хэрэгжүүлэхэд тусладаг бөгөөд, үнэлэмжийн хүртэхүй “бидний ухамсрыг үнэлэмжийг тодорхойлох абсолют хэм хэмжээг танин мэдэхэд чиглүүлдэг”. Өөрөөр хэлбэл үнэлэмжийг танин мэднэ гэдэг бол тухайн зүйл, үйл явдлын үнэлэмжийн жинхэнэ мөн чанарыг хэмжих хэм хэмжээг хүлээн зөвшөөрнө гэсэн үг юм. Лотцегийн хувьд энэ нь тухайн зүйл юунд зориулагдсаныг, хамгийн чухал нь бидний хувьд ямар утга холбогдолтой болохыг танин мэдэх явдал юм. Тэгэхээр хүн бол зөвхөн үнэлэмжийг танин мэдэгч биш бас үнэлэмжийг хэлбэржүүлэгч байдаг гэдгийг онцолсон (Pierson, 1988).

Лотце, Бүтээгч сүнс орчлон ертөнцийн бүтцэд, хувирч өөрчлөгдөшгүй хуулиудыг оноон, түүний дагуу феноменал ертөнцийг хөдөлгөж, Сайныг (Vida.F.Moore, 1901) хязгааргүй олон хэлбэр ба үйл явдлуудад түгээн, тэдгээрийгээ таашаал, аз жаргалын тухай ухамсарт шингээж байдаг шиг, хүн ч мөн адил эдгээр хуулийг хүлээн авч, оршихуйг үнэлэмжийн мэдлэг болгон хөгжүүлж, үнэлэмжээ өөрөөсөө урган гарч буй гадаад хэлбэрүүдэд шингээж байдаг гэжээ. Өөрөөр хэлбэл, үнэлэмж бол хөгжлийн зорилго ч мөн, арга хэрэгсэл ч мөн юм. Энэ бол Лотцегийн хувьд давтагдашгүй онцгой гэдэг элемент маш чухал гэдгийг харуулж байгаа бас нэг илэрхийлэл юм. Үнэлэмжийн энэхүү хөгжлийн үйл явц нь чөлөөт, давтагдашгүй байдлаар өрнөдөг. “Лотцегийн үзлээр үнэлэмжийн хөгжил бол чөлөөт үйл явц бөгөөд үнэлэмжийн давтагдашгүй онцгой байдлыг хүн бүр өөрийн давтагдашгүй нөхцөлд дахин давтагдашгүйгээр хувирган өөрчилдөг үйл ажиллагаа юм. Үүний үр дүн нь бодит байдлыг цаашид үнэлэх, хөгжүүлэх шинэ ‘хэм хэмжээ’ болж өгдөг. Харин энд ‘хэмжээ’ гэдэг нь зөрчиж болшгүй хатуу хууль бус, харин чөлөөт бүтээлч үйлдэл өрнөх боломжийг олгодог хүрээ юм. (Pierson, 1988)” Өөрөөр хэлбэл үнэлэмж бол гаднаас оноосон хууль, дотоод зайлшгүй шаардлагын аль нь ч биш, харин бүх зүйлд буй Абсолютын оршихуйн өвөрмөц илэрхийлэл ажээ. Үнэлэмж өөрийгөө хүмүүст илэрхийлдэг бөгөөд гэхдээ хүний оюун ухааны хязгаарлагдмал чадвартай зохицсон байдалтай байдаг. (Pierson, 1988). Лотцегийн үзлээр бол бодит байдлын жинхэнэ тогтолцоо бидний хязгаарлагдмал мэдлэгээс далд оршдог.

Лотцегийн үзлээр үнэлэмж, түүний уг гарал бол универсал, өөрчлөгдөшгүй, “Абсолют Сайн”<sup>11</sup> байна. Харин хүний төгсгөлт шинж бол “Сайн”-аас эхлэлтэй, абсолют, өөрчлөгдөшгүй хэм хэмжээнд чиглэсэн трансцендентал үнэлэмжүүдийг нэгдмэл бодит байдлаар ойлгохтой холбоотой бөгөөд хүмүүс түүнийг давтагдашгүй туршлагаар мэдэрч чаддаг гэсэн үг юм. Тэгэхээр үнэлэмж абсолют хэм хэмжээ болохынхоо хувьд өөрийгөө илэрхийлдэггүй ч тэд хүний практик оюун ухааны постулатууд болдог тул философийн үүднээс тэдгээрийг эргэцүүлэн ойлгох зайлшгүй шаардлага гардаг аж.

Уг гарал болон *telos*-ын хувьд аливаа үнэлэмж универсал, абсолют юм. Учир нь үнэлэмж Абсолютын имманент илэрхийлэл бөгөөд бүх бодит байдал эргээд Абсолют руу чиглэдэг гэж үзсэн. Үнэлэмжийн ийм амьд хөдөлгөөнийг динамизм хэмээн нэрлэж (Pierson, 1988) хөгжлийн тухай ойлголт нь эхлэл болон эцсийн зорилготой салшгүй холбоотой байдаг. Лотцегийн хамгийн чухал санааны нэг бол, үнэлэмж бол зүгээр нэг статик зарчим биш, харин амьд, динамик хүч юм. Энэ динамик

<sup>11</sup> Highest Good

хүч нь аливаа бодит байдлыг илүү төгс, илүү сайн байдал руу хөтөлдөг. Иймээс хүн төрөлхтөн өөрийн үйлдэл, бүтээлээр дамжуулан үнэлэмжийг бодит болгодог. Учир нь үнэлэмж бол зүгээр нэг хууль биш, харин амьд Абсолют (animate Geist)-ын оршихуйн баталгаа юм. Тодруулбал, аливаа үнэлэмж бодит байдалд амьд, нөлөөлөх хүч хэлбэрээр оршдог. Иймд тэдгээр нь аливаа юмс үзэгдлийн үйл ажиллагааг тодорхой зорилгод чиглүүлдэг ажээ.

Лотцегийн боловсруулсан үнэлэмжийн онол дахь метафизик агуулгын онцлог нь Прескотт Жонсоны үнэлснээр үнэлэмж, төгсөлт шинжтэй баримт хоёрыг спиритуаль ахуйд нэгтгэсэн метафизик синтезийг<sup>12</sup> бий болгосонд оршдог. Гэвч энэ синтез нь ертөнцийг ойлгох шинжлэх ухааны үзэл давамгайлах болсон нөхцөлд бэрхшээл бий болгож байна (Johnson, 2015) гэж шүүмжилсэн байна. Энэ нь “үнэний мадаггүй чанар бол баримтаас ангид байдаг” гэсэн Лотцегийн тайлбартай холбоотой.

Тэрээр үнэлэмжийг зорилгын хүрээнд тодорхойлохдоо, хүмүүс бодит байдлыг үнэн, хууль хэмээн ойлгож хүлээн авдаг ч үнэлэмж, үнэлэмжийн тухай мэдлэг бол бүх бодит байдлын эхний болоод эцсийн цэг, анхдагч эх (альфа, омега) сурвалжийн хувьд том орон зай эзэлдэг зүйл мөн. Тэрбээр бүхний уг гарал бол “хамгийн үнэтэй зүйл” биш харин үнэлэмж бүхий юм гэсэн. “Бид ‘сайхан’, ‘аз жаргал’, ‘баяр баясгалан’-г бүгдийг нь Сайн-д нэгтгэн үзэж, цогцоор нь (оюун ухаан, түүнтэй холбоотой бүхэн, түүнд захирагддаг бүхэн, ижил төстэй байгаа бүхэн, зорилгод хүрэх хэрэгсэл бүхэн) “үнэлэмж бүхий” гэж үздэг. Жинхэнэ бодит байдал гэдэг нь энэхүү Сайн бөгөөд Хамгийн Дээд Бурхан тэнгэр юм гэжээ. Улмаар тэрээр үнэлэмж гэдэг нь “Сайн” гэсэн ойлголт эсвэл матери төдий бус, харин Бурхан тэнгэрийн амьд, оюун санааны илэрхийлэл юм. Бодит байдалд илрэх бүх өвөрмөц, сайхан, сайн, үнэтэй бүхэн эцэстээ Бурхан тэнгэрийн мөн чанар, өвөрмөц илрэлүүд байдаг гэсэн байна<sup>13</sup>. Мөн эдгээр нь Сайнтай нэгдсэн, үнэлэмжтэй бүхнийг өөртөө багтаасан нэгэн цогц ажээ. Үнэлэмж нь зөвхөн түүнийг таашаан мэдэрч буй сүнс (оюун)-д л оршдог учраас, бодит байдал нь тодорхой зохион байгуулалт бүхий нэгэн тогтолцоо юм. Энэ тогтолцоо нь үзэгдлийн тодорхой ертөнцийг, мөн түүнийг тайлбарлан ойлгох тодорхой метафизикийн хэв маягуудыг бий болгодог (Ladd, 1884, p.152). Ингэснээр дээр дурдсан Хамгийн Дээд Сайн нь сүнсний хувьд таашаан хүртэх объект болж, боломжит олон янзын хэлбэрээр түүнд илэрч чаддаг.

Абсолют ахуйг ингэж сайхан, сайн хэмээх ойлголтуудтай нэгтгэн тайлбарласан тайлбар Лотцегоос өмнө Платон, Аристотелийн үзэлд ч гарч байсан билээ. Харин эдгээр ойлголтыг уламжлалт теологид холбон үзсэн нь түүний философийн нэг онцлог (Pierson, 1988) болно.

Үнэлэмж гэдэг ойлголтыг Лотце философи утгаар мөн чанараараа динамик, хөгжиж байдаг зүйл гэж нэрлэснийг цааш тайлбарлавал энэ нь уламжлалт байдлаар жинхэнэ ахуйн мөн чанартай холбон тайлбарлаж ирсэн ойлголтоос нэн ялгаатай шинжийг өгүүлсэн байна. Үнэлэмж нь хүний танин мэдэхүйн үйл явцад тохиолдох өвөрмөц үзэгдэл, юмс дундаас тухайн нөхцөлд өвөрмөцөөр илэрхийлэгдэж гарч ирэхээс гадна, хүн өөрөө идэвхтэйгээр үнэлэмжийг бүтээж, “үнэлэмжийн бодит

<sup>12</sup> The Origin of all does not merely "have the most worth" - it is value.

<sup>13</sup> Лотце Метафизик зохиолдоо энэхүү үнэлэмжийн бүгдэд орших шинжийг материал ертөнцөд холбон, хаана материаллаг элементүүд оршин байна, тэнд абсолют мөн адил оршдог гэж бичсэн аж. Гэхдээ энэ абсолют бол зүгээр нэг төсөөлөгдөж болох үзэл санаа, хийсвэр зүйл огтхон ч биш юм. Харин тэр бүхнээс дээгүүр, аливаа дотоод амьдралд бодитой байх мөн чанар юм. Мөн матери шиг хуваагдаж, янз бүрийн хэмжээгээр тархалгүй, харин тус бүрийн дотор илэрч, бүгдийг багтаан зохицуулдаг нэгдэл байдлаар оршино. Ингэснээрээ тэрхүү төгс зохицлын бүхэл төлөвлөгөөний дагуу тус бүрийн хамааралтай элементэд тэдний үйл ажиллагааг чиглүүлэх хүчийг өгч, тэдний үйлдлүүдийг тодорхой зорилгод чиглүүлэн нягт уялдуулдаг гэсэн байдаг бөгөөд Лейбницийн философи дахь монадтай бас харьцуулж болох ажээ.

байдал”-ын хөгжлийн үйл явцад оролцох бодит үүрэгтэй байдаг. Энэ хөгжлийн эцсийн чиглэл буюу төгс зорилго (telos) туйлын үнэлэмжтэй билээ. Хүмүүс өөрсдөө үнэлэмжийг илэрхийлэгч тэр бодит байдлын бүрэлдэхүүн хэсэг байсаар байдаг. Тодруулж хэлбэл, дээд үнэлэмж болох Бурхан тэнгэрийн динамик шинж энд тодорч байна.

Үнэлэмж нь субъектив сэтгэл хөдлөлийн илрэл бус, харин абсолют ахуйн хүрээнд объектив байдлаар оршиж, хүн түүнийг гоо зүйн танин мэдэхүйн чадвараар хүртэн ойлгодог. Мөн “үнэлэмж бол чадавхи бүхий мөн чанар (potent essence)<sup>14</sup>” бөгөөд юмсын үйл ажиллагааг чиглүүлээд зогсохгүй, бусад бүх юмтай зохицон уялдах байдлаар тэднийг “тодорхой зорилго”-д чиглүүлдэг. Энэ бол үнэлэмж үнэхээр юмс ба үйл явдал бүрд оршдог гэдгийн баталгаа ажээ (Pierson, 1988). Үнэлэмж абсолют ахуйн өвөрмөц илрэл болж бодитоор оршдогийг ийм байдлаар тэрээр тайлбарласан байна.

Лотце үнэлэмжийн санааг илэрхийлэхдээ адилтгал, зүйрлэлүүдийг ашигласан нь бий.

а) Жишээ нь, тэрээр үнэлэмж ертөнцөд илрэхдээ хүний зан чанар болон бие махбодиор нь илэрдэг гэж өгүүлсэн байдаг. Тухайлбал, хүний бие хөл, гар зэрэг бүх эрхтэн бүрэн байж сая нэг цогц болж, нэгэн зорилго, чиглэлд үйлчилдгийн адил, үнэлэмж нь хүн бүхэнд заяасан чадавхи бөгөөд нэгдмэл, цогц байдлыг илэрхийлдэг.

б) Түүний нэг алдартай зүйрлэл бол үнэлэмжийг хөгжмийн эгшигтэй адилтгасан явдал юм. Хөгжмийн эгшиг бүхэн өвөрмөц, бас хувийн шинжтэй байдаг гэсэн ч дараалал, гоо зүйн хэм хэмжээний дагуу өрнөдөг. Үүний нэгэн адил, үнэлэмж бодит байдлын янз бүрийн хэсэгт өвөрмөцөөр илэрдэг ч, бүгд нэгэн зорилго руу чиглэж байдаг. Иймд үнэлэмжийн систем нь нэгдмэл төгс зохицол бүхий зүйл юм. Аливаа зүйлд агуулагдах үнэлэмжийн мөн чанар бүр өвөрмөц байдаг боловч, бүгд эцсийн дүндээ абсолют телеологи хэм хэмжээний дагуу илэрдэг байна.

Ийнхүү Лотцегийн үзлээр байгалийн аливаа үзэгдэл, урлагийн бүтээл, зан үйл, ёс суртахуун, гоо зүйн субъектив мэдрэмжүүд, хүний ухамсарт үйл ажиллагаа, идэвхит сонголт бүгд Абсолют сайны илэрхийллүүд мөн бөгөөд үнэлэмж гэдэг бол хууль биш, харин амьд, хайр дүүрэн сүнслэг хүч юм. Бүх үнэлэмж эцсийн зорилгоороо Түүнд (Абсолют сайнд) чиглэдэг гэж тэрээр тодорхойлсон байна.

Эцэст нь нэмж өгүүлэхэд үнэлэмжийн мэдлэгийг Лотце үзэл баримтлалынхаа асуудал бүрт шингээсэн харагддаг. Лотце, өөрийн дараа үеийн антропологийн чиг хандлагаас ялгаатай нь хүнийг өөрийнх нь бүтээсэн техник, хэрэгслээр тайлбарлахыг зорьсонгүй. Харин түүний хувьд хүн төрөлхтнийг ойлгох түлхүүр нь түүхийн явцад бүрэлдэн хөгжсөн хүний боловсрол, соёл болон гэгээрлийн<sup>15</sup> үр дүнг судлахад оршино. Соёлын түүхээс эхлэн логик болон метафизик рүү чиглэсэн «урвуу» дарааллаар тэрээр өөрийн философи шинжилгээгээ явуулсан. Тэрээр регресс шинжилгээний аргыг ашиглаж (Milkov, 2006) соёлын түүхээр дамжуулан шинжлэх ухаан, математик, логик хэрхэн ажилладаг болохыг ойлгохыг хичээсэн. Тодруулбал, шинжлэх ухаанаар орлуулах боломжгүй боловсрол-соёлын гол үнэлэмж<sup>16</sup> нь яруу найраг болон шашнаар дамжин ирдэг гэж тэрээр үзэж байв. Эдгээр нь юмсад «дээрээс харах өнцөг» буюу «зүрх сэтгэлийн үзэл баримтлал»-ыг олгодог. Шинжлэх ухааны механицист тайлбар нь ертөнцийг ойлгох цорын ганц түлхүүр биш бөгөөд мөн хамгийн чухал нь ч биш юм. Шинжлэх ухаан нь зөвхөн түүхэн явцад бүрэлдсэн үнэлэмж болон боловсролын хэлбэрүүдтэй нэгдэж байж л «хүнлэг дүр төрхтэй» болдог (Milkov, 2006). Гэвч соёлын түүх логик, метафизик болон шинжлэх ухааны

<sup>14</sup> Чиглүүлэгч, идэвхтэй зарчим шинжтэй

<sup>15</sup> Bildung

<sup>16</sup> Bildungsgüter

хэлбэрийг хэрхэн тодорхойлдог вэ? Хариулт нь: ёс зүйн дээд эрхэмлэлүүд; логикийн хүчин төгөлдөр байдал<sup>17</sup>; гоо зүйн үнэ цэнээр дамжуулан тодорхойлогдох явдал юм. Тодорхойлогдох боломжтой хэмжигдэхүүн болохын хувьд эдгээр дээд эрхэмлэлүүд нь «чиг баримжаа олгох ойлголтууд» болж өгдөг. Орон зайн дэг журам нь мөн ийм идеал чанар юм. Кантыг баримтлан Лотце эдгээр нь материаллаг бодит байдалд бус, харин оюун санааны анхдагч бодит байдалд хамаардаг гэж тодорхойлсон байна. Гэхдээ тэдгээрийг илэрхийлэхэд (экспликаци хийхэд) матери шаардлагатай. Энэ нь бидэнд «сайн», «муу», «цэнхэр», «чихэрлэг» гэх мэт ойлголтуудын талаарх априори (туршлагаас өмнөх) төсөөлөл байдаггүйн учир юм. Бид тэдгээрийг зөвхөн туршлагаар дамжуулан «дагалдах буюу хоёрдогч бодол»<sup>18</sup> байдлаар ойлгодог. Түүнчлэн, бид аливаа хүчин төгөлдөр утга холбогдол болон үнэлэмжийг туршлагаас ийм л аргаар гарган авдаг. Цаашлаад, яг ижил аргаар бид хүчинтэй байдал ба үнэлэмжийг туршлагаас уламжлан гарган авдаг. Ийм идеалууд бидний мэдрэхүйн амьдралд, таашаал ба дургүйцлийн мэдрэмжинд аль хэдийн үйлчилж байдаг нь маш чухал. Тэднийг бид цаашлаад ёс зүй, гоо зүй, шинжлэх ухаан, математик, метафизик болон логикт дахин олж хардаг (Milkov, 2006) ажээ. Лотцегийн боловсруулсан Wertbegriff буюу үнэлэмж бол түүний философийн тогтолцооны чухал ач холбогдол бүхий ойлголт гэдэг нь эндээс харагдаж байна.

Дүгнэж хэлбэл, тэрээр үнэлэмжийг объектив шинжтэй гэдгийг нь нотлон харуулахын тулд түүний давтагдашгүй, зорилгот байдлыг нь онцлохын хамт Абсолют Сайн, Бурхан тэнгэр, түгээмэл шинж гэсэн ахуйн категориудаар тодотгосон юм. Энэ нь түүний үнэлэмжийн философи бол телеологи идеализм болохыг илтгэнэ. Мөн хүн бол зөвхөн бэлэн орших үнэлэмжийг танин мэдэгч төдий бус, мөн таашаал, өвдөлтийг мэдрэн хариу үйлдэл үзүүлэгч төдий бус харин ёс суртахуун, гоо зүй, оюун санааны үйл ажиллагаагаараа дамжуулан үнэлэмжийг бүтээн хэрэгжүүлэгч оршихуй гэж үзсэн нь субъектийн онцлогийг, түүний туршлагыг давтагдашгүй шинжтэй болохыг харуулсан хэрэг болно.

### Teleological Idealism: Hermann Lotze's Conception of Value

*This article highlights how Lotze develops the concept of value in a manner distinct from traditional philosophical thoughts that regard it as possessing the same ontological status as real being. In doing so, it emphasizes his view of value as an objective, irreducible, and purposive principle, as well as his account of the human capacity to apprehend value through feeling and sensibility. The article further elucidates how Lotze explains the human being as a creative and distinctive subject by articulating this capacity in terms of a "sixth sense," or aesthetic faculty. His central aim was to unify law, fact, and criteria of value into a coherent whole. He explained that the criteria of value manifest themselves through the feelings of pleasure and pain, which he considered real phenomena. According to him, the source of value is the Absolute, or the Highest Good, toward which all reality is directed. Lotze understood value as living and active, defining the human being not only as a perceiver of value, former but also as a creator of it. Thus, his theory of value shows that his philosophy is ideal, teleological, and grounded in the objective and purposive character of value.*

<sup>17</sup> Validity

<sup>18</sup> Nebengedanken